

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 8 2022 оны 6-р сар

ТАНИЛЦУУЛГА

Канад улсын Гадаад хэргийн яамнаас санхүүжүүлж буй “Монгол улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” (MERIT) төсөл “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК хариуцан хэрэгжүүлж буй Салхитын ордын Хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах төсөл (цаашид “жишиг төсөл” гэх)-ийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудын дэмжлэгтэйгээр хамтран хэрэгжүүлж байна.

Жишиг төслийн нэгдүгээр үе шат 2021 оны 9-р сараас 2022 оны 4-р сарын хооронд хэрэгжсэн бөгөөд энэ хугацаанд эрх зүйн орчны шинжилгээ, байгаль орчны төлөв байдлын судалгаа, эрсдэлийн үнэлгээ зэрэг суурь судалгаа, дүн шинжилгээний ажлууд болон уурхайн хаалтын зорилго, зорилтыг талуудын оролцоотой боловсруулах ажлуудыг хийж дуусгав.

Төслийн эхний шатны хэрэгжилттэй холбоотой мэдээллийг <http://portal.merit.mn/> болон <https://www.facebook.com/MERIT.mn> хуудаснаас авна уу.


Жишиг төслийн хоёрдугаар үе шат энэ оны 6-р сараас хэрэгжиж эхлэв. Канад болон олон улсын шилдэг туршлагыг Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн нэвтрүүлэх, хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах үндэсний зөвлөхүүдийн баг болох салбар бүрийн мэргэжилтнүүдээс бүрдсэн техникийн багийг сонгон шалгаруулж бүрдүүлэв. Канадын байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Си Пи Пи Энвайронментал” корпораци уг техникийн багийг мэргэжил, арга зүйн удирдамжаар чиглүүлж, чадавхжуулж ажиллана. MERIT төслийн хувьд оролцогч талуудын хамтын ажиллагааг хангах, төслийн удирдлагаар дэмжих ажлуудыг хариуцна.

Хоёрдугаар шатанд УУХҮЯ, БОАЖЯ, МХЕГ, Усны газар, АМГТГ болон Дундговь аймгийн болон Гурвансайхан сумын удирдлага, нутгийн иргэд зэрэг төслийн оролцогч талуудын уулзалтыг сар тутам зохион байгуулж, төсөл хэрэгжилтийн явц, үр дүнг тухай бүрд танилцуулж, санал авч байх болно. Түүнчлэн, орон нутгийн түвшинд сумын иргэд, малчидтай зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, төслийн талаар мэдээлэл хүргэж, санал хүсэлтийг нь хаалтын төлөвлөлтөд тусгах болно. “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-ны хувьд хаалтын төлөвлөгөөний тодорхой бүлгүүдийг боловсруулах, зөвлөхүүдэд ложистик туслалцаа үзүүлж хамтран ажиллана. Монгол улсад уурхайн хаалтын төлөвлөлт хийх стандарт жишиг бий болгоход УУХҮЯ ихээхэн ач холбогдол өгч буй юм.

УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АГУУЛГА

Салхитын ордын хаалтын менежментийн төлөвлөгөөг Монгол улсад мөрдөгдөж буй “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын холбогдох шаардлагуудад нийцүүлэн боловсруулна. Хаалтын төлөвлөлтийн баг (үндэсний зөвлөхүүд, “Си Пи Пи Энвайронментал” корпораци, MERIT) төслийн эхний үе шатанд гүйцэтгэсэн эрх зүйн орчны дүн шинжилгээ хийж, Монгол улсын холбогдох бүх эрх зүйн шаардлагуудыг нарийвчлан тодорхойлсон “Лавлах хүснэгт”-ийг боловсруулсан билээ. Техникийн баг хаалтын төлөвлөгөөний бүтэц, дэс дарааллыг тодорхойлоход уг “Лавлах хүснэгт”-ий үндэслэл болгон ашиглана.

Түүнчлэн, төслийн эхний үе шатанд тус уурхайн хаалтын зорилго, зорилтыг талуудын оролцооны зарчмаар боловсруулж санал нэгдсэн билээ. Хаалтын нөхөн сэргээлтийг төлөвлөхөд эдгээр зорилго зорилтыг удирдамж болгох юм. Дараах зурагт эхний үе шатанд боловсруулж, санал нэгдсэн хаалтын зорилго, зорилтуудыг танилцуулж байна.



Мөн төслийн I шатанд эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийхэд “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-тай нягт хамтран ажилласан. Уг судалгаагаар уурхайн талбайд үүсэж болзошгүй эрсдэлийн хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж, тодорхойлсон эрсдэлүүд нь хаалтын зорилго, зорилтын хэрэгжилт, нөхөн сэргээлтийн эцсийн үр дүнд нөлөөлөх магадлал, үр дагаврыг тодорхойлж, хаалтын төлөвлөлтөд хариу арга хэмжээг оновчтой шийдвэрлэх нь чухал.

Төлөвлөгөөний үндсэн агуулгад уурхайн танилцуулга, байгаль орчны төлөв байдлын суурь мэдээлэл, гадаргуу хэлбэршүүлэлтийн дизайн, дэд бүтцийн ашиглалт, хөрс, ургамлыг нөхөн сэргээх төлөвлөгөө, ан амьтдын амьдрах орчин, гадаргын болон газрын доорх ус, агаарын чанар, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, оролцогч талуудын оролцоо, нийгэм-эдийн засгийн шилжилт төлөвлөгөө, хаалтын санхүүгийн зардлын тооцоо зэрэг бүлгүүдийг хамруулна.

■ ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ

Ирэх саруудад MERIT төслийн баг, олон улсын болон үндэсний зөвлөхүүдийг оролцуулсан чадавх бэхжүүлэх сургалтуудыг үе шаттай зохион байгуулна.

Эдгээр сургалтаар уурхайн хаалтын үндсэн сэдвүүдтэй холбоотой олон улсын сайн туршлагаудыг танилцуулах, үндэсний зөвлөхүүдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, цаашид нутагшуулах чадавхыг бий болгох үндсэн зорилготой.

Тухайлбал, хаалтын нөхөн сэргээлт, гадаргуу хэлбэршүүлэлтийн дизайн шийдэл, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зэрэг Монгол улсын хувьд харьцангуй шинэ мэдлэг ойлголтыг танилцуулах болно. MERIT төслийн хамт олон хаалтын менежментийн төлөвлөлт хийх чиглэлүүдээр мэдлэг түгээх, чадавх бэхжүүлэх цуврал сургалт зохион байгуулах гэж буйдаа баяртай байна.

Бид дараа дараагийн мэдээнд уурхайн хаалтын төлөвлөгөө, чадавх бэхжүүлэх сургалтуудын талаар дэлгэрэнгүй танилцуулна.

■ ТӨСЛИЙН ХУГАЦАА

Төслийг улирлаар үечилж хэрэгжүүлнэ:

- Нэгдүгээр улирал: 2022.06.15-2022.09.15
- Хоёрдугаар улирал: 2022.09.16-2022.12.15
- Гуравдугаар улирал: 2022.12.16-2023.03.15
- Дөрөвдүгээр улирал: 2023.03.16-2023.06.15

Хаалтын менежментийн төлөвлөгөөний бүлгүүдийг эхний гурван улиралд багтаан боловсруулж дуусахаар төлөвлөж байна. Дөрөвдүгээр улиралд төлөвлөгөөг нэгтгэн, мэргэжлийн болон хууль эрх зүйн хяналт, сайжруулалт хийсний дараа “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-д хүлээлгэн өгнө. Төсөл хэрэгжилтийн явцад оролцогч талуудыг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгүүд зохион байгуулж, санал зөвлөмжийг хүлээн авч төлөвлөгөөнд тухай бүрд нь тусгана.

■ 6-Р САРЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

- 6-р сарын 15-ны өдөр сонгон шалгаруулсан Үндэсний зөвлөхүүдэд чиглэл зөвлөмж өгөх эхний уулзалт хийлээ.
- 6-р сарын 21-ний өдөр “Си Пи Пи Энвайронментал” корпорациас үндэсний зөвлөхүүдэд төслийн менежментийн программ хангамжийн сургалт зохион байгуулав.
- 6-р сарын 24-ний өдөр Жишиг төслийн II үе шатны албан ёсны нээлтийг хийж, гол оролцогч талууд болох УУХҮЯ, БОАЖЯ, МХЕГ, аймаг орон нутгийн төлөөллийг урьж оролцуулав.



Жишиг төслийн 2-р үе шатны нээлтийн хурал



Үндэсний зөвлөхүүдэд чиглэл өгөх уулзалт

- 6-р сарын сүүлийн долоо хоногт MECSZB байгаль орчны зөвлөх компани Салхитын уурхайд ажиллаж, байгаль орчны дээж судалгаа (хөрс, ус, хог хаягдал) хийхээр төлөвлөж байна.

ХОЛБОО БАРИХ

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл

Төслийн захирал **Р.Алтангэрэл**тэй имэйл хаягаар холбогдоно уу.

✉ r.altangerel@merit.mn